



Г

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Г.ГҮНБАТ ТАНАА

Г

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 571

танай -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд

заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагаан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Г.Гүнбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 111014941569 бүртгэлийн дугаартай Гүндэнсамбуу овогтой Гүнбатын Цагаан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Г.Гүнбатын мөрийн хөтөлбөр 2 хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч “Г.Гүнбат”-д

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



**ДОРНОД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ЦАГААН-ОВОО СУМАНД БИЕ ДААН  
НЭР ДЭВШИГЧ ГҮНДЭНСАМБУУ ОВОГТОЙ ГҮНБАТЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР**

Цагаан-Овоо сум

2024 07 22

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Монгол улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль, “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, зэрэг баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай” хуулийн 37.1 дэх заалтын дагуу боловсруулав.

**Мөрийн хөтөлбөрийн зорилго:**

Нутгийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн, нутаг дэвсгэрийн хөгжлийн тодорхой асуудлуудыг иргэдийн оролцоотой, бодит үндэслэлтэйгээр нутгийн өөрөө удирдах байгууллагаар шийдвэр гаргуулах түүнийг хариуцлагатай хэрэгжүүлэхэд чиглэн ажиллана.

**1. Эрүүл иргэн**

- 1.1. Эрүүл мэндийн мэдлэгтэй, идэвхтэй амьдралыг дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг хамаарал бүхий оролцогч талуудтай, тухайлбал боловсролын байгууллагатай хамтран ажиллах, уялдаа холбоог сайжруулахад санаачилгатай ажиллана.
- 1.2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог тогтмол хүртээмжтэй зохион байгуулахад анхаарч ажиллана.
- 1.3. Монгол улсын үндсэн хуулиар олгогдсон иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эрүүл мэндээ хамгаалах үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран, санаачилгатай ажиллана.

**2. Орлоготой иргэн**

- 2.1. Бус нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнесийг дэмжих, иргэн бүр ажилтай, орлоготой болох орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарал хандуулж, бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2. Бус нутгийн онцлогт тохирсон бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг, хагас эрчимжуулсэн аж ахуйтай хослуулах байдааар малчин иргэдийг тогтмол орлоготой байх санал санаачилга, малчдын бүлэг, хоршоо, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

**3. Эрүүл байгаль, эрүүл мал, эрүүл хүнс**

- 3.1. Эрүүл байгаль, эрүүл мал, эрүүл хүнс орон нутгийн хөтөлбөрийг салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран санаачилж орон нутгийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уядуулан хэрэгжүүлнэ.

- 3.2. Эрүүл байгаль, соргог бэлчээрийг хамгаалах, хадгалахын тулд бэлчээрийн даац, хэт ашиглалтыг бууруулах, бэлчээрийн зөв менежментийг малчин, малчдын бүлэг, хоршоодын дэмжлэгтэй хэрэгжүүлэхэд санаачилга гаргаж ажиллана.
- 3.3. Малын эрүүл мэндийн асуудлыг холбогдох төрийн байгууллага болон салбарын эрдэмтэн, холбогдох төсөл хөтөлбөртэй хамтран санаачилж, бус нутгийн онцлогт нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачилга гаргаж ажиллана
- 3.4. Сум орон нутгийг эрүүл баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангахад төр хувийн хэвшлийн хамтын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын хүнсний ногоогоор хангах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлд идэвх санаачлагчтай ажиллана.
- 3.5. Иргэдийн ундны усны чанар нь стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд иргэдийн оролцоонд түшиглэж итгэмжлэгдсэн лабораторийн байгууллагатай хамтран ажиллах, стандартын шаардлага хангасан усан хангамжийн бий болгоход анхаарч ажиллана.

#### **4. Хүртээмжтэй боловсрол**

- 4.1. Сум орон нутагт чанартай хүртээмжтэй боловсролыг эзэмших боломжийг нэмэгдүүлэх, чадварлаг боловсон хүчин багш бэлтгэхэд орон нутгийн хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

#### **5. Орон нутгийн хариуцлагатай засаглал**

- 5.1. Иргэдийн оролцоотой, бодит үндэслэлтэй шийдвэр гаргахад, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавихад нутгийн өөрөө удирдах байгууллагад манлайлж, зөв зөргээр нөлөөлж, идэвх санаачилгатай ажиллана.
- 5.2. Орон нутгийн иргэдийн оролцоог бүхий л хэлбэрээр хангах зарчим баримталж, сонгогчидтой тогтмол холбоотой ажиллах, тэднээс тавьсан санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхэд идэвх санаачилгатай ажиллана.
- 5.3. Монгол улсын хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг иргэдийн дунд зохион байгуулж, тэдний саналыг авч, нэгтгэх ажлыг идэвх санаачилгатай гүйцэтгэнэ.

БОЛОВСРУУЛСАН:

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

Г.ГҮНБАТ

Хаяг: Дорнод аймаг, Цагаан-Овоо сум, 2-р баг, Элст боон

Регистрийн дугаар: ЖЯ87102019

Утас: 99910289

Мэйл хаяг: [gunbat4@gmail.com](mailto:gunbat4@gmail.com)